

2023 оны Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл

“Монгео” ХК-ийн Хувьцаа Эзэмшигчдийн 2023 оны ээлжит хурлыг 2024 оны 04-р сарын 28-ны 10:00 цагт өөрийн байранд хуралдав.

Оролцсон нь:

Н.Соёмбо – ТУЗ-ийн дарга

Ц.Алтансүх- ТУЗ-ийн гишүүн

М.Алтанцэцэг – ТУЗ-ийн гишүүн

Н.Тулга – ТУЗ-ийн гишүүн

Э.Норовринчин – ТУЗ-ийн гишүүн

Х.Анар – ТУЗ-ийн гишүүн

М.Адилбиш – ТУЗ-ийн гишүүн

Б.Нямдэлгэр – ТУЗ-ийн гишүүн

Т.Батжаргал – ТУЗ-ийн гишүүн /томилолттой /

А.Ганцэцэг- Компанийн ня-бо

Н.Бат-өлзий- Компанийн ажилтан

Г.Даваажаргал – Компанийн ажилтан

Б.Түмэнжаргал – Компанийн ажилтан

Хурлын дарга Н.Соёмбо - 2023 оны ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц 79,6 хувьтай байна. Мал төлөлтийн ажлаар хөдөө явж байгаа ТУЗ-ийн гишүүн Т.Батжаргал хуралд ирэхгүй шалтгаантай. Саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчид болон бусад ТУЗ-ийн гишүүд ирсэн байна гэснээр хурлын ажиллагааг эхлүүлэв. Хурлын нарийн бичгийн даргад Б.Нямдэлгэрийг дэвшүүлж 100 хувийн саналаар томилов.

2023 оны ээлжит Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг Х.Анар , хэлэлцэх асуудлуудыг М.Алтанцэцэг нар танилцуулна.

Хэлэлцсэн нь :

Х.Анар: Хуулийн хүрээнд зохион байгуулагдаж буй тус хурал 10:00 цагт эхэлж 11:40 цагийн үед өндөрлөнө гэсэн дэгийг танилцуулав.

Хурлаар хэлэлцэх асуудлууд :

а. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн жилийн эцсийн тайлангын талаар ТУЗ-ийн хурлын шийдвэрийг хэлэлцэж батлах,

б. Санхүүгийн тайланг үнэлсэн "Шинэ Их Тэрбум Аудит" ХХК-ийн дүгнэлтийг сонсгох,

в. Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр улсын болон орон нутгийн чанартай зохион байгуулагдах ажилд компани идэвхтэй оролцох, шаардагдах төсвийг тооцож ТУЗ-ийн хурлаар шийдвэрлүүлэх,

г. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор их хэмжээний гэрээ хэлцэл байгуулах, зээл авахыг гүйцэтгэх захиралд зөвшөөрөх,

д. ХУДүүрэгт байрлалтай компанийн эзэмшлийн газрыг ашиглах, түрээслэх үйл ажиллагааг зохион байгуулахыг гүйцэтгэх удирдлагад даалгах, гэж ТУЗ-ийн гишүүн гүйцэтгэх захирал М.Алтанцэцэг танилцууллаа.

Жилийн санхүүгийн тайлангийн талаар :

2023 оны хувьд 143 сая төгрөгийн түрээсийн орлого олсон үүнээс 135 сая төгрөгний холбогдох зардал буюу ашиглалт, цалин хөлс, бусад зардал гарсан байна гэж компанийн ня-бо А.Ганцэцэг сонсгов.

Гүйцэтгэх захирал М.Алтанцэцэг: Бид өнгөрсөн жилийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын болон, ээлжит ТУЗ-ийн хурлаас гарсан шийдвэрүүд, холбогдох байгууллагууд болох Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн Биржээс баталсан журам, албан тоот зэргийг үндэслэн үйл ажиллагаагаа явууллаа. Компани ҮЦТХТ ХХК-тай гэрээ байгуулан, үнэт цаас хадгаламжийн болон үнэт цаастай холбогдолтой төлбөр тооцоог хугацаанд төлж барагдуулан ажилласан байна.

Компанийн эзэмшлийн байрны өрөөнүүдийг 98 хувь түрээслэн үйл ажиллагаагаа явуулж байна. Өнгөрсөн онд ХУД-ийн 12-р хорооны нутагт байх ногооны газрыг тодорхой хугацаагаар түрээслэн ажиллалаа. Үндсэн үйл ажиллагааныхаа чиглэлээр үйл ажиллагаагаа явуулах хүсэл сонирхолтойгоо илтгэн холбогдох байгууллагад хүсэлт хүргүүлж байлаа. Ажилтнуудын цалинг 28-66 хувь хүртэл нэмэгдүүлж ажиллалаа.

Компанийн үйл ажиллагааг тогтвортой явуулах үүднээс үндсэн үйл ажиллагааны чиглэлээр зохион байгуулагдах ажилд компани идэвхтэй оролцохоор бэлтгэл ажлыг зохион байгуулсан. Холбогдох дээд байгууллагад санал хүсэлтээ явуулсан байгаа. Шийдвэр ирвэл компани шаардагдах төсвийг тооцож баталгаажуулахад асуудал гарахгүй хэмээн танилцууллаа.

Компанийн тогтвортой үйл ажиллагааг хангах, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай их хэмжээний гэрээ хэлцэл байгуулах, зээл авахыг гүйцэтгэх удирдлагад зөвшөөрөх эс зөвшөөрөх тухай ТУЗ-ийн дарга Н.Соёмбо танилцуулав.

Мөн тэрээр ХУД-ийн 12-р хорооны нутаг дэвсгэрт байх 8 га газрын ашиглалтыг компанийн гүйцэтгэх захирал, менежер, ня-бо нарт даалгах нь зүйтэй байна гэв.

Санал шүүжлэл :

Н.Соёмбо: За тэгэхлээр хурлаар хэлэлцэх асуудлууд, тайлангуудтай танилцаж сонслоо. Ер нь татварын өрийг төлж дуусгах тал дээр анхаарч ажиллах шаардлагатай. 2024 ондоо бизнес төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж ТУЗ-аар батлуулан зохих шийдвэрүүдийг гарган ажиллах нь зүйтэй байх. Хурлаас гарах шийдвэрүүдийг хүлээн авна. Ер нь тухайн жилдээ ээлжит хурлаас гарсан, хуралд ярьсан зүйлийн хэрэгжилтэнд ТУЗ-ийн гишүүд анхаарал хандуулан ажиллалаарай гэв.

Б.Нямдэлгэр : Жилийн эцсийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангуудтай танилцлаа. Ер нь ойрын он жилүүдэд санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор шинээр бизнес төлөвлөгөөг төлөвлөх, компанийн нөөц бололцоон дээр тулгуурлан санхүүгийн чадамжийг сайжруулах зорилгоор хамтран бүгд ажиллацгаая. Хурлаас гарах шийдвэрүүдийг хүндэтгэн хүлээн авах болно.

Н.Тулга: Компанийн жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангуудыг сонсож мэдлээ. Өрийн асуудал дээр гүйцэтгэх удирдлага болон бид бүхэн анхаарч ажиллах нь зүйтэй гэж бодогдоно. Компанийн ТУЗ-ийн гишүүний хувиар бүх ажилд гар бие оролцон ажиллах болно. Хурлаас гарах шийдвэрүүдийг дэмжиж ажиллана. Бас нэг зүйлийг онцлоход жижиг хувьцаануудыг төвлөрүүлэх талдээр анхаарч ажиллавал зүйтэй санагдана. Ирэх онд нарийвчлан тооцож гаргасан, бүгд хэлэлцсэн, хэрэгжих боломжтой бизнес төлөвлөгөөтэй болох нь чухал.

М.Алтанцэцэг : ХАА-н салбарын бүтээгдэхүүн боловсруулах, нийлүүлэх жижиг үйлдвэр цехтэй болбол зүгээр байх. Өнгөрсөн өвлийн байдлыг харсан ч ийм байдал дахин давтагдахгүй гэх баталгаа байхгүй. Ирээдүйг харсан чиг бодлоготойгоор компанийн ХУД-ийн нутаг дэвсгэрт байх газрыг эргэлтэнд оруулбал санхүүгийн чадамж орлогын хувьд их л эерэг үр дүн гарах ёстой гэж санагдана. Энэ тал дээр анхаарч ажиллавал зүйтэй болов уу? Компанийн татварын өрийг барагдуулах талдээр анхаарч ажиллана гэв.

Ц.Алтансүх : 2023 оны жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангуудын талаар сонсож танилцлаа. Ажилтнуудын цалинг тодорхой хувиар нэмсэн нь сайшаалтай. Одоо ирэх онуудад компанийн санхүүгийн чадавхийг сайжруулах, татваруудын өрийг барагдуулах, аль болохоор ашигтай ажиллах тал дээр анхаарч ажиллах нь зүйтэй. Үүний тулд бизнес төлөвлөгөөг судалгаатай оновчтой хэрэгжүүлж болохуйц, тооцоо сайтайгаар шинэчлэн боловсруулах нь зүйтэй гэж санагдаж байна. Жил жилд бизнес төлөвлөгөөний хэрэгжилт болоод үр дүнг ярилцаж алдаа, оноогоо дүгнэж байх нь зүйтэй. Мөн компанийн жижиг хувьцаа эзэмшигчидтэй болон холбогдох брокерийн пүүсүүдтэй холбоотой ажиллаж хувьцааг төвлөрүүлэх ажиллагааг шат дараатай хэрэгжүүлэх нь ач холбогдолтой байх болов уу гэж бодож байна. Хурлаас гарах шийдвэрийг дэмжиж хүлээн авна.

Н.Соёмбо : Санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны тайлан, аудиторын дүгнэлттэй танилцлаа. Компанийн санхүүгийн чадамжийг дээшлүүлэх үйл ажиллагааны чиглэлийг үндсэн чиглэлээс гадна өөр чиглэлийн үйл ажиллагаа руу түлхүү чиглүүлж тодорхой дэс дараатай ажлуудыг зохион байгуулж төлөвлөх нь

зүйтэй. Мөн хувьцаат компанийн давуу байдлыг ашиглаж нээлттэй хувьцаа гаргаж хөрөнгө босгох арга замыг хайж үүнд тохирсон холбогдох урт хугацааны бизнес төлөвлөгөөг боловсруулж ажиллах хөрөнгө оруулагчидтай хамтарч үндсэн болон бусад чиглэл дээр төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ажиллах арга зам судлах хэрэгжүүлэх шаардлагатай байна. Энэ ажлыг зохион байгуулах талдээр гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч хэрэгжилтийг хянаж ажиллах шаардлагатай гэж үзэж байна. Хурлаас эцэслэн гарсан шийдвэрийг хүлээн авахаа илэрхийлье.

Х.Анар : Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаар сонслоо. Байгууллагын хувьд үндсэн үйл ажиллагааны чиглэл дээр тодорхой арга хэмжээнүүдийг жил бүр авахаар идэвхийлэн санаачлага гарган ажиллаж байгаа.

Гэвч холбогдох байгууллагаас манай компанийн туршлага, хийсэн ажлын тайланг төдийлөн ач холбогдол өгч хамтран ажиллах нөхцөл бололцоогоор хангаж өгөхгүй байгаа нь нэг талаас харамсалтай боловч нөгөө талаас бид үйл ажиллагааны чиглэлээ өөрчилж бизнес төлөвлөгөө, төслийг хэрэгжүүлж өөр салбарт хүч үзэн үйл ажиллагааны цар хүрээгээ нэмэх боломж нээлттэй харагдаж байгаа нь сайшаалтай. Иймд компанийн хувьцаа эзэмшигчид, удирдлагууд та бүхэн маань дараа дараагийн ажлын төлөвлөгөө, болон бизнес төлөвлөгөөнд онцгой анхаарал хандуулж бизнесийн төрөл хүрээгээ нэмэгдүүлж, санхүүгийн болон үйл ажиллагааны чиглэлийг өргөжүүлэн өөрчлөх, ашиг орлого олох, цаашлаад ашигтай ажиллах тал дээр онцгой анхаарч үйл ажиллагаагаа явуулах нь чухал гэдэг саналыг дэвшүүлж байна. Хурлаас гарах шийдвэрүүдийг хүндэтгэн хүлээн авна.

А.Ганцэцэг: Бид санхүүгийн чадамжийн хувьд энэ жил ашгийн түвшин маш бага, өр төлбөрийн хувьд татварын өглөгүүдтэй гарч байгаа нь манай байгууллагын санхүүгийн үзүүлэлт ямархуу түвшинд явж байгаа нь цаашдаа юун дээр анхаарч ажиллах, юунд чиглэж үйл ажиллагааны болон бизнес төлөвлөгөөг батлах гэх мэт олон асуудал дээр онцгой анхаарч ажиллах цаг нь тулж иржээ гэж харж байна. Иймд та бүхэн байгууллагын санхүүгийн цар хүрээг дээшлүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх үндсэн үйл ажиллагаа болон бусад чиглэл рүү онцгой анхаарч ажиллах тал дээр цаг алдалгүй судалгаа шинжилгээ хийж төсөл, төлөвлөгөө, болон бизнес төлөвлөгөөг гарган ажиллах шаардлагатай байна гэдгийг илтгэж байна гэж харагдана. Үүн дээр анхаарч ажиллах нь зүйтэй байхаа. Энэ удаагийн хурлаас гарах шийдвэрийг хүндэтгэн хүлээн авахаа илэрхийлж байна.

Э.Норовринчин: Компанийн үйл ажиллагаа санхүүгийн байдал, аудиторын дүгнэлттэй танилцлаа. Үндсэн чиглэлээсээ хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж үр дүнг нь харах хэрэгтэй. ТУЗ-ийн гишүүний хувьд хурлаас гарах шийдвэрийг зөвшөөрч үйл ажиллагаанд нь идэвхитэй оролцоно гэдгээ хэлье гэснээр санал шүүмжлэлийг таслав.

Шийдвэрлэсэн нь :

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайланг зөвшөөрөхөөр ,
2. 2023 оны жилийн санхүүгийн тайланг зөвшөөрөхөөр ,
3. Аудиторын дүгнэлтийг хүлээн авахаар ,
4. Компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр улсын болон орон нутгийн чанартай зохион байгуулагдах ажилд идэвхтэй оролцох, шаардлагатай төсвийг нарийн тооцож тухай бүрт нь ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж шийдвэрлүүлэхээр ,
5. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх , бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор их хэмжээний гэрээ хэлцэл байгуулах зээл авахыг гүйцэтгэх захиралд зөвшөөрөхөөр ,
6. Компанийн эзэмшлийн ХУД-т байрлалтай газрыг зөв зохистой, үр дүнтэй ашиглах зорилгыг агуулсан болон компанийн бизнес төлөвлөгөөг тооцож шинэчлэн боловсруулахыг ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх удирдлагад үүрэг болгохоор ,
7. Хурлаас холбогдох шийдвэрүүдийг гаргахаар тус тус шийдвэрлэв.

Хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 13 цаг 20 минутанд дуусгалаа.

Тэмдэглэл хөтөлсөнМ.Алтанцэцэг /

